



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар A/163

Булган сум

**Удирдлагын баг бүрэлдэхүүн шинэчлэн
томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1.1, 67.1.2, 67.1.4, 67.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын баг бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдлагын бүрэлдэхүүний ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдлагын багийн хурлыг батлагдсан журмын дагуу зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтанд мэдэгдэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/763 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



03

Аймгийн Засаг даргын 20²⁵ оны
... дугаар сарын 19-ны/ний өдрийн 4/163 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт



Аймгийн Засаг даргын удирдлагын багийн бүрэлдэхүүн

Аймгийн Засаг дарга

Аймгийн Засаг даргын орлогч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө

оруулалтын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Худалдан авах ажиллагааны газрын дарга

Аймгийн ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Автотээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь төвийн дарга

23

дугаар сарын

Аймгийн Засаг даргын 2025 оны
19-ны/ний өдрийн 2/163 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
УДИРДЛАГЫН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.21 дэх заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг баримтална.

Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын баг, түүний ажиллах журмыг аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын баг нь аймгийн Засаг даргаас хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой шийдвэр буюу иргэдийг Төрийн дээд шагналд уламжлах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлэх, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэн сайжруулж, санал, зөвлөгөө, дүгнэлт өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Удирдлагын багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

Нэг. Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлын зохион байгуулалт:

1.1. Удирдлагын багийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс жил бүрийн эхэнд гарган, аймгийн Засаг даргаар батлуулна. Хурлыг сар бүрийн 3 дахь долоо хоногийн Лхагва гараг бүр зарлан хуралдуулна.

1.2. Хурлыг аймгийн Засаг даргын зөвшөөрснөөр зарлан хуралдана.

1.3. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хурлын тов, зарыг хурал болохоос 3 хоногийн өмнө мэдэгдэж, хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, материалыг гишүүдэд хүргүүлнэ.

1.4. Цаг үеийн шинжтэй болон аймаг орон нутагт тулгамдсан асуудлыг тухай бүрд нь тус хурлын төлөвлөгөөнд оруулж хэлэлцүүлнэ.

1.5. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын материалыг холбогдох хэлтэс нь 2 хоногийн өмнө гишүүдийн цахим хаягаар илгээж, аймгийн Засаг дарга болон орлогчид цаасан хэлбэрээр хүргүүлнэ. Хурлаар хэлэлцүүлэх асуудал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Тухайн асуудлыг хэлэлцүүлэх шаардлага, үндэслэл бүхий танилцуулга (тооцоо судалгааг хавсаргах)

Гаргах шийдвэрийн төсөл

Албан хөтлөлтийн стандартыг хангасан байх

1.6. Энэхүү журмын 1.5-д заасан шаардлагыг хангаагүй материалыг хүлээн авахгүй

1.7. Хурлаар хэлэлцүүлэх асуудлыг Засаг даргын Тамгын газрын хэлтсээс оруулж танилцуулахаас гадна агентлагууд бодлогын хэлтсээр дамжуулан хуралдаанд хэлэлцүүлнэ.

1.8.Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хамаарах хэлтэс, агентлагийн удирдлага, мэргэжилтэн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг хуралд оролцуул

1.9.Хуралд аймгийн ИТХ-ын дарга, аймгийн ерөнхий Аудитор нарыг урилгаар оролцуулж болно.

1.10.Нэн даруй шийдвэрлэх тулгамдсан асуудал гарвал аймгийн Засаг дарга, түүний орлогчийн санаачилгаар Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно.

1.11.Хурлын бэлтгэл хангах ажлыг Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны бодлого, дотоод ажил хариуцсан түшмэл хариуцна.

1.12.Хурлын тэмдэглэлийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн холбогдох мэргэжилтэн хөтөлнө. Хурлын тэмдэглэлд хэлэлцсэн асуудал, гарсан асуулт хариулт, санал дүгнэлтийг бүрэн тусгаж, хэлэлцүүлсэн асуудлын танилцуулгыг хавсаргана.

Хурлын тэмдэглэл нь албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан байна. Шаардлагатай үед дуу хураагчид хурлыг явцыг бичиж хадгална. Хурлын тэмдэглэлийн шаардлагатай хэсгийг холбогдох байгууллага албан тушаалтан хурал болсноос хойш ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

Хоёр. Удирдлагын багийн хурлын дэг:

2.1. Хурлыг аймгийн Засаг дарга удирдана.

2.2. Аймгийн Засаг даргыг эзгүй үед түүний орлогч хурлыг удирдана.

2.3.Хурал даргалагч хэлэлцэх асуудлыг танилцуулна. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй боловч тухайн үед хурлаар зайлшгүй хэлэлцүүлэх шаардлагатай асуудал гарвал хурал даргалагчийн зөвшөөрснөөр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж оруулж болно.

2.4. Хурал даргалагч төлөвлөгөөнд тусгагдсан дарааллын дагуу асуудлыг хэлэлцүүлнэ.

2.5.Хурлаар хэлэлцүүлж буй асуудлын танилцуулга нь 15 минутаас хэтрэхгүй байна.

2.6.Танилцуулгын дараа хурал даргалагчийн зөвшөөрсний дагуу асуулт асууж, хариулт авна.

2.7.Асуулт, хариулт дууссаны дараа эхлээд зөвлөлийн гишүүд, дараа нь хуралд оролцож буй бусад хүмүүс саналаа хэлнэ.

2.8.Хурал даргалагч хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан, Зөвлөлийн гишүүдийн саналыг сонссоны дараа дүгнэлтээ хэлж, дараагийн асуудлыг хэлэлцэж эхэлнэ.

2.9.Хурлын үеийн завсарлага, хугацааг хурал даргалагч шийдвэрлэнэ

Гурав. Бусад зохицуулалт:

3.1.Удирдлагын багийн гишүүд хуралд баримтлах дэгийг сахиж хэлэлцэж байгаа асуудалд анхааралтай хандаж, асууж лавлах, санал хэлэхдээ хурал даргалагчаас зөвшөөрөл авна.

3.2.Хурлын үеэр утсаар ярих, хурал даргалагчийн зөвшөөрөлгүйгээр түр гарахыг хориглоно.

3.3.Хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг аймгийн цахим хуудсанд тухай бүр байгуулж нийтэд мэдээлнэ